

# **ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**/ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСӨЛ/**

**ЗАХИАЛАГЧ: ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**

**СУДЛААЧ: Б.БАТЦЭЦЭГ**

## **АГУУЛГА**

### **УДИРТГАЛ**

#### **НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

#### **ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ**

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:

2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:

2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:

2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал:

#### **ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

3.3. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

3.4. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

#### **ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ**

4.1. Үнэлэлт, дүгнэлт

4.2. Зөвлөмж

#### **АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ**

## УДИРТГАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар зүйлийн 5.1.22 дахь хэсэгт “Хууль зүйн судалгааны чанарыг шинэ түвшинд гаргаж, хууль тогтоомжийн боловсруулалт, хэрэгжилтийг судалгаанд суурилан хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ” гэж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-т “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх” гэж тус тус тусгасан.

Энэ хүрээнд 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн “Хууль тогтоомжийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу Захиргааны ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд холбогдох судалгааг хийсэн болно.

Уг судалгаагаар Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, уг төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах замаар Захиргааны ерөнхий хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд чиглэсэн хуулийн төсөл боловсруулахад хууль санаачлагчид дэмжлэг үзүүлэх, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхийг зорисон болно.

# **ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

## **НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Энэхүү үнэлгээг “Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

“Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал” - /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийсэн.

1. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх;
4. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх.

## **ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих байдал
3. Ойлгомжтой байдал
4. Зардал
5. Харилцан уялдаа зэрэг болно.

### **Зорилгод хүрэх байдал:**

Шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх /бүрэн илэрхийлж чадсан эсэх/, хуулийн төслийн үндсэн зорилго нь Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлснээс хойш уг хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэхэд зарим саад бэрхшээл тулгарч байгаа тул уг шалтгааныг эрт илрүүлэх, цаашид хуулийг боловсронгуй болгоход чиглэгдэж байгааг анхаарч, хуулийн төслийн зохицуулалт, арга хэмжээ нь хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой байна уу гэдгийг үнэллээ. Энэхүү үнэлгээг хийхийн тулд хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авав.

### **Практикт хэрэгжих боломж:**

Шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ гэдгийг тогтоох, тэдгээр байгууллагад тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг урьдчилан үнэлэх шалгуур үзүүлэлт юм.

**Ойлгомжтой байдал:**

Хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

**Хүлээн зөвшөөрөгдөх байдал:**

Шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд тодорхой этгээдүүдэд үүрэг хүлээлгэсэн, аж ахуйн байгууллагын салбарт хүндрэл үүсгэх зохицуулалтыг тусгаагүй тул хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авах шаардлагагүй гэж үзэв.

**Зардал:**

Хуулийн төсөл нь төрийн байгууллага, хуулийн этгээдэд холбогдох зардал үүсгэхээр зохицуулсан байх тул уг хоёр субъектэд үүсэх зардлыг “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцохоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгов.

**Харилцан уялдаа:**

Хуулийн төслийг бүхэлд нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай зэрэг холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

**ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН  
БАЙДАЛ**

Энэ хэсэгт хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгон авлаа. Энэхүү зүйл заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс хуульд нэмэлтээр орж буй голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож, тухайн сонгож буй зүйл заалтын үр нөлөөг судлах болно.

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт тус бүрээр авч үзвэл:

**“Зорилгод хүрэх байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийнэ.

Монгол Улсын Их Хурлаас 2015 онд Захиргааны ерөнхий хуулийг баталж, 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд уг хууль нь Монгол Улсад анх удаа захиргааны суурь харилцааг бүхэлд нь нэгтгэн

зохицуулснаараа эрх зүйн хөгжилд төдийгүй захиргааны байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй, иргэдийн оролцоог хангадаг байх зорилгод хүрэхэд ихээхэн ач холбогдолтой болсон юм.

Гэсэн хэдий ч Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлснээс хойш уг хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэхэд практикт зарим саад бэрхшээлүүд тулгарсаар байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалд туссан дээрх үндэслэл, хэрэгцээ шаардлагаас дүгнэвэл нь Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлснээс хойш уг хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэхэд зарим саад бэрхшээл тулгарч байгаа тул уг шалтгааныг эрт илрүүлэх, давхар, хийдэл, зөрчлийг арилгах, цаашид хуулийг боловсронгуй болгоход хуулийн төслийн зорилго чиглэгдэж байна.

Аливаа хуулийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн байх ёстой учраас нэн түрүүнд хуулийн төслийн зорилгыг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлага, үндэслэл болон зорилготой харьцуулан дараахь байдлаар үнэлэх хэсгээ тогтоолоо.

Хуулийн төслийн хэрэгцээ шаардлага (хуулийн төслийн үзэл баримтлалаас)	Хуулийн төслийн зорилго
<p>Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-ийн 5.1.20-д “Төрийн захиргааны албан тушаалтан иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх хугацааг хоёр дахин бууруулж, хөнгөн шуурхай болгоно.” гэж, Монгол Улсын Их Хурлын 2017 оны “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 11 дүгээр тогтоолын хавсралтын 151-д “Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах”-аар, 144-т Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасны дагуу өргөдөл, гомдол шийдвэрлэх хугацааг богиносгох, иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг захиргааны байгууллага шийдвэрлэхдээ иргэдийн оролцоог хангах, хэрхэн шийдвэрлэх асуудлыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх зорилгоор Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тус тус заасан байна.</p>	<p>Захиргааны ерөнхий хууль болон бусад хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчил арилж, хуулийг нэг мөр ойлгож, хэрэглэх боломж бүрдэнэ. Түүнчлэн иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх нэгдсэн нэг журамтай болж, түүнийг шийдвэрлэх хугацаа богиносноор иргэн, хуулийн этгээдэд ээлтэй, хариуцлагатай захиргаатай байх төрийн зорилгыг хангах</p>

Түүнчлэн хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн эсэхийг үнэлэх үүднээс хуулийн төслийн зорилго, зорилтод хүрэхэд чиглэсэн дараахь зохицуулалтын үр нөлөөг үнэлэхээр сонголоо.

Хуулийн төслийн Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 8, 10,11,13 болон 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг сонгон авлаа

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд өргөдөл гөргөх8 шийдвэрлэх ажиллагааг тусгасан хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 12 дахь хэсгийг сонгож авлаа.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа. /Хуулийн төсөл 6 зүйлтэй./

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо. /Хуулийн төсөл 6 зүйлтэй./

### ДӨРӨВ.УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгсэлийг хүснэгтийн дагуу тогтоолоо. Үүнд:

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 8, 10,11,13 болон 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх
2.	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь	Хууль тогтоомжийн тухай хууль 29, 30 дугаар зүйл, хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах
3.	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 12 дахь хэсэг	Холбогдох зохицуулалтын практик нөхцөл байдалд шинжилгээ хийх
4.	Зардал	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу тусад нь тооцно.	Тооцоолон гаргах
5.	Харилцан уялдаа	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгуудаар шалгах

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараахь байдлаар үнэллээ.

#### **4.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Энэ хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд томъёолсон зорилго, зорилт болон зохицуулалттай харьцуулан үзлээ.

Хуулийн төслийн үзэл баримтлалаас харахад одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Захиргааны ерөнхий хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох, хуулийг нэг мөр ойлгоход болон Түүнчлэн иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх нэгдсэн нэг журамтай болж, түүнийг шийдвэрлэх хугацаа богиносноор иргэн, хуулийн этгээдэд ээлтэй, хариуцлагатай захиргаатай байх төрийн зорилгыг хангахад хуулийн төслийн зорилго оршиж байна.

Хуулийн төслийн зохицуулалтууд нь хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн эсэх, тэдгээр нь зорилгыг хангах боломжтой байдлаар томъёологдсон эсэхийг үнэлэхээр хуулийн төслийн зорилгыг сонгож авсан дараахь зохицуулалтуудтай харьцуулан дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 8, 10,11,13 болон 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

**1 дүгээр зүйл.**Захиргааны ерөнхий хуульд доор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг, заалт, тайлбар нэмсүгэй:

#### **8/92 дугаар зүйлийн 92.3, 92.4, 92.5, 92.6, 92.7 дахь хэсэг:**

“92.3.Гомдол нь үнэн зөв байна.

92.4.Гомдлыг төрийн албан ёсны хэлээр бичгээр, эсхүл амаар, эсхүл тухайн захиргааны байгууллагын албан ёсны цахим хаягт цахим сүлжээгээр дамжуулан гаргаж болно.

92.5.Бичгээр гаргасан гомдолд овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын буюу шуудангийн хаягаа бичиж, гарын үсэг зурна. Хүндэтгэн үзэх шалтгаанаар гарын үсэг зурах боломжгүй бол бусдаар төлөөлүүлэн зурж болно.

92.6.Гомдлыг хоёр, түүнээс дээш тооны иргэд хамтран гаргасан бол түүнд бүгд гарын үсэг зурах, эсхүл тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурж, төлөөлөх эрхээ нотлох баримт бичгийг хавсаргана.

92.7.Амаар гаргах гомдлыг тухайн захиргааны байгууллагын гомдол гаргагчийг хүлээн авах байранд очиж гаргана.”

#### **10/93<sup>1</sup> дүгээр зүйл:**

#### **“93<sup>1</sup> дүгээр зүйл.Гомдлыг хүлээн авах, бүртгэх**

93<sup>1</sup>.1.Захиргааны байгууллага гомдол гаргагчийг хүлээн авч уулзах байр, гомдол хүлээн авах ажилтан ажиллуулна. Гомдлыг захиргааны байгууллагын ажиллах цагийн хуваарийн дагуу хүлээн авна.

93<sup>1</sup>.2.Гомдол гаргагчийг хүлээн авах байранд ирж амаар гаргасан гомдлыг түүнийг хүлээн авах үүрэг бүхий албан тушаалтан тэмдэглэн авч, тусгай бүртгэлд бүртгэнэ.

93<sup>1</sup>.3.Бичгээр болон цахим сүлжээгээр дамжуулан ирүүлсэн гомдлыг энэ хуулийн 93<sup>1</sup>.2 дахь хэсэгт заасан албан хаагч хүлээн авч, дарааллын дагуу бүртгэнэ.



93<sup>1</sup>.4.Гомдлыг хүлээн авсан албан тушаалтан шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтанд ажлын нэг өдөрт багтаан шилжүүлнэ. Гомдлыг түүнд холбогдож байгаа албан тушаалтанд өөрт нь шилжүүлэхийг хориглоно.”

### **11/93<sup>2</sup> дугаар зүйл**

#### **“93<sup>2</sup> дугаар зүйл.Гомдлыг хянан шийдвэрлэхгүй байх**

93<sup>2</sup>.1.Дор дурдсан үндэслэл байвал захиргааны байгууллага гомдлыг хянан шийдвэрлэхгүй байж болно:

93<sup>2</sup>.1.1.гомдол нь тодорхой нэр, хаяггүй бол;

93<sup>2</sup>.1.2.эрх зүйн чадамжгүй, эсхүл шүүхийн шийдвэрээр эрх зүйн чадамжгүйд тооцогдсон этгээд эцэг, эх, асран хамгаалагчаараа төлөөлүүлээгүй бол;

93<sup>2</sup>.1.3.тухайн захиргааны байгууллагад гомдол гаргагч этгээд уг асуудлаар өмнө хандаж байсан бөгөөд түүнийг шийдвэрлэсэн бол;

93<sup>2</sup>.1.4.гомдолд дурдсан асуудлаар шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр байгаа бол;

93<sup>2</sup>.1.5.гомдол нь энэ хуулийн 92<sup>1</sup> дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй бол;

93<sup>2</sup>.2.Энэ хуулийн 93<sup>2</sup>.1 дэх хэсэгт заасан үндэслэл бий болвол захиргааны байгууллага энэ талаар гомдол гаргагчид мэдэгдэх буюу гомдлын бүртгэлд бүртгэнэ.”

Монгол Улсын Их Хурлаас 1995 онд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг батлан гаргаж, уг хуулиар иргэдийн төрийн байгууллага, албан тушаалтанд хандан гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмыг зохицуулж байгаа бөгөөд 2015 онд Захиргааны ерөнхий хууль батлагдан мөн хуулийн 9 дүгээр бүлэгт “Гомдол шийдвэрлэх журам” гэсэн зохицуулалт тусгасан.

Захиргааны Ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.2-т захиргааны актад гаргах гомдолд тавигдах шаардлагыг тодорхойлохдоо 10 дугаар зүйлийг эшилсэн байгаа тул ЗЕХ-ийн дагуу гомдлыг хянан шийдвэрлэх харилцаанд уг хууль хэрэглэгдэж иргэдийн гаргасан гомдлыг шийдвэрлэх талаар хоёр хуульд зэрэгцсэн буюу давхардсан зохицуулалтыг бий болоод байна.

Түүнчлэн зарим тохиолдолд салбарын хууль тогтоомжоор эрх олгогдсоны дагуу батлагдсан захиргааны хэм хэмжээний актаар гомдлыг шийдвэрлэх процесс журамласан байх ба захиргааны байгууллагаас уг журмыг хэрэглэх нь түгээмэл байна. Тухайлбал, Татварын маргаан таслах зөвлөл нь Татварын ерөнхий хуульд зааснаар татварын байгууллага, улсын байцаагчийн шийдвэр (захиргааны акт) –тэй холбогдуулан гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх ганцхан гэж хэлж болох чиг үүрэгтэй, Захиргааны ерөнхий хуулийн 93 дугаар зүйлд заасан гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага байна.

Энэхүү байгууллагын үндсэн чиг үүрэг нь татвар төлөгчөөс татварын албаны акт, дүгнэлт гэсэн хоёр төрлийн шийдвэрт гаргасан гомдлыг шийдвэрлэх бөгөөд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг гомдлыг хүлээж авах, буцаах гэх мэтэд харилцаанд хэрэглэгддэг. Татварын ерөнхий хуульд Татварын алба болон Маргаан таслах зөвлөл нь уг хуулийн 72.1-д заасны дагуу гаргасан гомдлыг хянан шийдвэрлэхдээ Захиргааны ерөнхий хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Маргаан таслах зөвлөлийн ажиллах журмыг хамтад нь дагаж мөрдөхөөр зааснаас үүдэн гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагаанд зэрэгцсэн олон хуулийн зохицуулалт хэрэглэгдэх мэт, улмаар

Захиргааны ерөнхий хуульд заасан гомдлыг хянан шийдвэрлэх процессын зохицуулалт хэрэглэгдэхгүй байх нөхцлийг үүсгэж байсан юм.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулиар “иргэн” гэж тухайлан зааснаас “хуулийн этгээд”-ээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх асуудлыг орхигдуулсан, гомдлыг шийдвэрлэх журам хэт ерөнхий, санал, мэдэгдлийн шинжтэй “өргөдөл” шийдвэрлэх журамтай адилтган зохицуулсан, өргөдөл, гомдол шийдвэрлэх хугацаа хэт урт хугацаа тогтоосон юм.

Техник технологи хөгжсөн, одоо үед захиргааны байгууллагын үйл ажиллагааны чиг хандлага, үзэл баримтлал өөрчлөгдсөнтэй холбоотойгоор өргөдөл, гомдол шийдвэрлэж байгаа хугацааг одоо байгаагаас богиносгох шаардлагыг харгалзан иргэн, хуулийн этгээдэд захиргааны байгууллагаас аль болох хүндрэл багатай үйлчлүүлэх нөхцлийг бүрдүүлэх нь чухал юм. Мөн хуулийн төсөлд гагцхүү гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага гомдлыг шийдвэрлэх эрхтэй гэсэн зохицуулалт тусгагдсан нь ихээхэн ач холбогдолтой болсон байна.

Харин хуулийн төсөлд гомдол гаргах хэлбэрийг амаар болон бичгээр эсхүл цахим сүлжээгээр дамжуулан гомдол гаргана гэж заасан байх ба энэ тохиолдолд 1111 гэх мэт утсаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэх нь зохицуулалтгүй үлдэхээр байна.

Түүнчлэн хуулийн төслийн 11 дүгээр зүйлд заасанчлан тодорхой тохиолдлуудад гомдлыг шийдвэрлэхгүй байж болно гэсэн нь хэдийгээр захиргааны байгууллага ямар тохиолдолд гомдлыг хүлээн авахаас татгалзах боломжтойг заасан мэт боловч нөгөө талаас гомдлыг хүлээн авч шийдвэрлэж ч болохоор хоёрдмол байдлаар бичигдсэн байна. Энэ нь гомдол гаргагч иргэн хуулийн этгээдэд хуулийг ойлгон хэрэгжүүлэхэд хүндрэл учруулахаар байна.

**1 дүгээр зүйл.** Захиргааны ерөнхий хуульд доор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг, заалт, тайлбар нэмсүгэй:

**13/103 дугаар зүйлийн 103.5, 103.6 дахь хэсэг:**

“103.5.Төрийн албан хаагчийн мэргэжлийн үйл ажиллагаанаас учирсан хохирлыг төр хүлээнэ.

103.6.Төрийн албан хаагчийн мэргэжлийн үйл ажиллагааны улмаас учирсан хохирол болон хамтын удирдлагатай байгууллагын үйл ажиллагаанаас учирсан хохирлыг хариуцан арилгах журмыг Засгийн газар батална.”

Иргэний хууль, Захиргааны ерөнхий хууль бусад холбогдох хууль заасны дагуу төрийн буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирлыг төр барагдуулж байгаа боловч төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоогүй байдал, хууль хэрэгжүүлэх талаар санаачлагагүй ажилладаг, хүний нөөцийн хомсдол, буруутай этгээдээс төрд учруулсан хохирлыг буцааж хэрхэн гаргуулж авах талаарх процессыг нарийвчлан журамлаагүйгээс буцаагаад төрийг хохиролгүй болгох тухай хуулийн зохицуулалт хэрэгжихгүй байна.

Түүнчлэн төрийн буруутай үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг төр хариуцан барагдуулах хуулийн зохицуулалтын хэрэгжилт нь Төсвийн тухай хуулийн дагуу төсөв боловсруулах, батлуулах хугацаанаас хамаарч өмнөх оны шүүхийн шийдвэрээр олгогдох хохирлын төлбөр дараа онд хуримтлагдах хүндрэл үүсч байна. Гэтэл төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээд хохирох явдал жил ирэх тутам нэмэгдэж байгаа нь улсын төсөвт нилээд ачаалал үүсгэж байна.

Нөгөө талаар төрийн албан хаагчийг хариуцлагатай байлгах, төр албан хаагчийн ямар төрлийн алдаа дутагдлын улмаас үүссэн хохирлыг хариуцах, аль хэсгийг албан тушаалтнаас буцаан гаргуулах талаарх зохицуулалт, хамтын удирдлагатай байгууллагын учруулсан хохирлыг буруутай этгээдэд хэрхэн ногдуулах, буруутай этгээдээс төрд учирсан хохирлыг гаргуулах асуудлыг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага үүсээд байсан юм.

Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.2 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана.” гэж заасан ба хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 13-т заасан зохицуулалт нь төрийн албан хаагчийн хувийн хариуцлагагүй үйлдлийн улмаас учирсан хохирол болон мэргэжлийн үйл ажиллагааны улмаас учирсан хохирол гэж тусад нь салгасан байна. Хуулийн төслийн зохицуулалтаас харахад төрийн албан хаагчийн мэргэжлийн үйл ажиллагааны улмаас бусдад учруулсан хохирлыг төр хариуцан арилгахаар тусгасан байгаа нь төслийн үзэл баримтлалд заасан зорилгодоо хүрсэн гэж дүгнэж болохоор байна.

Харин энэхүү процессийг нарийвчлан зохицуулсан журмыг хэм хэмжээний актаар зохицуулах ба уг актаар /Төрийн албан хаагчийн мэргэжлийн үйл ажиллагааны улмаас учирсан хохирол болон хамтын удирдлагатай байгууллагын үйл ажиллагаанаас учирсан хохирлыг хариуцан арилгах журам/-р зөвхөн төрөөс хохирлыг хариуцан арилгах процессийг зохицуулахаар байна. Учирсан хохирлын хэмжээ нь холбогдох хууль тогтоомжид заасан үндэслэлээр тогтоогдох ба төрийн байгууллага хариуцан арилгана. Үүнд журмаар зохицуулах харилцаа төдийлөн шаардахгүй.

Гэтэл журмаар зохицуулах шаардлагатай мэргэжлийн үйл ажиллагааны улмаас учруулсан хохиролд юуг тооцох, хохирлыг хэрхэн нэхэмжлэх, хэрхэн төсөвт тусгах болон буцаагаад буруутай этгээдээс хэрхэн нэхэмжилж гаргуулах талаар зохицуулалт орхигдож болзошгүйг анхаарах шаардлагатай байна.

**3 дугаар зүйл.**Захиргааны ерөнхий хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг дор дурдснаар өөрчлөн найруулсугай:

**1/3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалт:**

“3.1.7.Улс төрийн шийдвэр гаргах ажиллагаа, Улсын Их Хурлаас тодорхой асуудлаар чиглэл өгсний дагуу хэрэгжүүлсэн Засгийн газар, түүний харьяа захиргааны байгууллагын тухайн шийдвэр гаргах ажиллагаа;”

Захиргааны ерөнхий хуульд “төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага” нь захиргааны байгууллага болно гэж заасан бөгөөд Монгол Улсын Засгийн газар, яам, агентлаг багтахаар байна. Харин 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш Монгол Улсын Засгийн газрыг Захиргааны хэргийн шүүхэд хариуцагчаар татаж хэрэг шийдвэрлэсэн тохиолдол гарчээ.

Засгийн газрын үйл ажиллагааг бодлогын, буюу захиргааны гэж хоёр ангилан авч үзэж байгаа ба Засгийн газрын захиргааны үйл ажиллагаагаар иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдсэн бол захиргааны хэргийн шүүх зөрчигдсэн эрхийг сэргээдэг. 2017 онд Засгийн газраас гаргасан 106 шийдвэрийн 8.55% хувь буюу 9 нь захиргааны акт, 42.4% хувь буюу 45 нь захиргааны хэм хэмжээний акт байна.

Захиргааны ерөнхий хуульд зааснаар “улс төрийн шийдвэр гаргах ажиллагаа” нь Захиргааны хэргийн шүүхийн харьяалалд хамаардаггүй. Гэтэл шүүгч нар төдийгүй бусад хууль хэрэглэгч нар энэ талаар тодорхой мэдлэг хангалтгүй, үзэл бодлын зөрүүтэй байдгаас хууль хэрэглээнд маргаан үүсгэж, Засгийн газрын чухам аль шийдвэр нь Захиргааны хэргийн шүүхийн хяналтад байх нь тодорхойгүй байдал үүсгэж байна.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагаагаар иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдсэн бол захиргааны болон иргэний хэргийн шүүх тус тусын хэргийн харьяаллын дагуу маргааныг шийдвэрлэх нь тодорхой байна.

Хуулийн төсөлд тусгаснаар “Улсын Их Хурлаас тодорхой асуудлаар чиглэл өгсөний дагуу” гэжээ. Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Улсын Их Хурал нь хууль тогтоох дээд байгууллага бөгөөд түүний гаргаж буй аливаа шийдвэр нь хуулийг хэрэгжүүлэгч болох гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч Засгийн газарт чиглэл өгсөн шинжтэй байна. Үүнээс үзвэл “тодорхой асуудал”-аар бус, Улсын Их Хурлын тогтоолын дагуу хэрэгжүүлсэн Засгийн газрын бүхий л ажиллагаа Захиргааны хэргийн шүүхийн хяналтаас гарах нөхцөл бүрдэж байгааг анхаарах шаардлагатай байна.

Түүнчлэн Засгийн газрын хэрэгжүүлэгч болон тохируулагч агентлагуудад Улсын Их Хурал чиг үүргээрээ шууд чиглэл өгдөггүй тул “түүний харьяа захиргааны байгууллагын тухайн шийдвэр гаргах ажиллагаа” гэсэн зохицуулалт нь үзэл баримтлалд дурдсан зорилгодоо хүрэхэд маргаан дагуулахаар байна. Тодруулбал, шууд Улсын Их Хурлаас тодорхой үүрэг өгсөн тохиолдолд маргааныг Захиргааны хэргийн шүүх хянахгүй байх уу, эсхүл Улсын Их Хурал Засгийн газарт чиглэл өгсөний дагуу төрийн захиргааны байгууллагын хэрэгжүүлсэн үйл ажиллагаа хамаарах уу гэдэг нь тодорхойгүй байдал үүсгэхээр байна.

#### **4.2. “Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

##### **12/99<sup>1</sup> дүгээр зүйл:**

##### **“99<sup>1</sup> дүгээр зүйл.Өргөдөл гаргах, шийдвэрлэх**

99<sup>1</sup>.1.Иргэн, хуулийн этгээд нь төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар саналын шинжтэй, Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан өөрийн эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийг талаар хүсэлтийн шинжтэй өргөдлийг захиргааны байгууллагад гаргах эрхтэй.

99<sup>1</sup>.2.Захиргааны байгууллагад иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдөл нь энэ хуулийн 92<sup>1</sup> дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

99<sup>1</sup>.3.Захиргааны байгууллага энэ хуулийн 93<sup>1</sup> дүгээр зүйлд заасан журмын дагуу иргэн, хуулийн этгээдээс гаргасан өргөдлийг хүлээн авч, бүртгэнэ. Энэ хуулийн 93<sup>2</sup> дугаар зүйлд заасан үндэслэл өргөдөлд нэгэн адил хамаарна.

99<sup>1</sup>.4.Өргөдөлд дурдсан асуудлыг шууд шийдвэрлэх боломжтой бол захиргааны байгууллага энэ хуулийн 94.3 дахь хэсэгт заасан хугацаанд зохих шийдвэрийг гаргаж, өргөдөл гаргагчид мэдэгдэнэ.

99<sup>1</sup>.5.Шууд шийдвэрлэх боломжгүй бөгөөд удаан хугацаанд шийдвэрлэгдэх асуудал /орон сууж олгуулах гэх мэт/-аар гаргасан өргөдлийг тусгай бүртгэлд бүртгэж, шийдвэрлэлтэд хяналт тавина.

99<sup>1</sup>.6.Саналын шинжтэй өргөдлийг хүлээн авч, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг судалсны үндсэн дээр зохих арга хэмжээ авах, эсхүл зохих хариуг 60 хоногт багтаан өгнө.”

Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгаснаар Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль болон Захиргааны ерөнхий хуулийн давхацсан зохицуулалтыг арилгаж, хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд ач холбогдолтой болжээ.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулиар өргөдлийг 90 хүртэл хоногоор сунган шийдвэрлэх боломжтой байсныг богиносгож 60 хоног болгосон нь иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлэхэд чухал болсон байна.

Харин төсөлд шийдвэр гаргахдаа “зохих шийдвэр гаргана” гэсэн байна. Уг төслөөс уншихад өргөдөлд дурдсан асуудалтай хамааралтай шийдвэр гаргахыг зохицуулсан байх ба гаргах шийдвэр нь ямар хэлбэртэй гарах нь тодорхойгүй байна.

Захиргааны байгууллагын өргөдөл шийдвэрлэхтэй холбоотойгоор гаргаж буй аливаа шийдвэр нь захиргааны акт байх тул хуульд зааснаар амаар болон бичгээр гаргах боломжтой гэж тайлбарлаж болох боловч хууль хэрэглэгчдэд тодорхойгүй байдал үүсгэх, захиргааны байгууллага өөрийн үзэмжээр тайлбарлах нөхцөл үүсч болзошгүйг анхаарах шаардлагатай байна.

#### 4.3.“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгах үүднээс судлаачийн зүгээс хуулийн төслийн ойлгомжтой байдалд дүн шинжилгээ хийсэн болно.

Дд	Хуулийн төслөөс ойлгомжгүй байгаа зохицуулалт	Тайлбар	Санал
	93.3.4.гомдлын шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг тогтмол хугацаанд гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх, жил бүр нийтэд тайлагнах;	“тогтмол” гэх үг нь өөрөө хугацаа заасан утгыг агуулж байна.  Түүнчлэн “холбогдох байгууллага” гэсэн нь ямар байгууллага болох нь тодорхойгүй байна.	Төслийн уг хэсгээс “хугацаа” гэснийг хасах, “холбогдох байгууллага” гэснийг “гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих эрх бүхий байгууллагад” гэж өөрчлөх
	93.4.Гомдлыг хүлээн авч, бүртгэх, шийдвэрлэлтэд хяналт тавих, шийдвэрлэлтийн талаарх тайлан мэдээ гаргах, холбогдох байгууллагад хүргүүлэх журмыг Засгийн газар батална.	Төслийн бичвэрээс харахад гомдлыг холбогдох байгууллагад хүргүүлэх	“холбогдох байгууллага” гэснийг “гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавих эрх

		/шилжүүлэх/ эсхүл тайланг холбогдох байгууллагад хүргүүлэх нь тодорхойгүй байдал үүсгэж байна	бүхий байгууллагад” гэж өөрчлөх
	93 <sup>2</sup> .1.Дор дурдсан үндэслэл байвал захиргааны байгууллага гомдлыг хянан шийдвэрлэхгүй байж болно:	Төслөөс үзэхэд дурдсан нөхцөл байдал үүсвэл гомдлыг шийдвэрлэх эсэх нь үзэмжийн асуудал байхаар зохицуулсан байна. Энэ нь хуулийг хэрэглэгчдэд ойлгомжгүй хүндрэлтэй байдал үүсгэх магадлалтай.	Төслөөс “байж болно” гэснийг хасах
	93.3.2.харьяаллын дагуу ирсэн гомдлыг заавал хүлээн авах, эрх хэмжээний хүрээнд хянан үзэж үндэслэлтэйгээр шийдвэрлэх; 93.3.3.гомдлыг хуульд заасан хугацаанд нь барагдуулах, гомдолд дурдсан төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах;	Төсөлд агуулгын хувьд ижил ойлголтыг “гомдлыг шийдвэрлэх” болон “гомдлыг барагдуулах” гэж 2 өөрөөр томъёолсон байна.	Төсөлд хэрэглэсэн нэр томъёог жигдлэх

Түүнчлэн энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгасан.

Үүнд:

№	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1.	29.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх	
	29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

	асуудлыг бүрэн тусгасан байх;	
	29.1.3. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Хуулийн төсөл зохицуулах харилцаа, хүрээнээс хальсан зүйл судалгаагаар тогтоогдоогүй.
	29.1.4. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
	29.1.5. зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
	29.1.6. хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
	29.1.7. бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
	29.1.8. тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
	29.1.9. шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
	29.1.10. Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон бусад хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх.	Бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулаагүй байна.
	29.1.11. хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

	зарчим, хүрэх үр дүнг тусгана	
--	-------------------------------	--

<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага.</b>	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3 -т “Тайлбар: Гадагш чиглэсэн гэж тухайн байгууллагын дотоод зохицуулалтын шинжийг агуулаагүй, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас <b>заавал</b> дагаж мөрдөхөөр журамласныг ойлгоно.”  Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 9 -д 93.3.2.харьяаллын дагуу ирсэн гомдлыг <b>заавал</b> хүлээн авах, эрх хэмжээний хүрээнд хянан үзэж үндэслэлтэйгээр шийдвэрлэх;
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

#### **4.4.“Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг “Аргачлал батлах тухай” Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалын дагуу тооцлоо.

#### **4.5.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзлээ.

Хуулийн төслийн уялдаа холбоо /Аргачлалын 4.10-т заасан шалгуурыг хангасан эсэх:/

№	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1.	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
2.	Хуулийн төслийн хууль	Тийм	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй



	ТОГТООМЖ гэсэн хэсэгт заасан хуулийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх		асуудал тогтоогдоогүй.
3.	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёонд нийцэж байгаа эсэх	Тийм	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
4.	Хуулийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Тийм	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
5.	Хуулийн төслийн зүйл, заалт хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Үгүй	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
6.	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм	Хуулийн төслөөр хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан байна.
7.	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Үгүй	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
8.	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
9.	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Үгүй	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
10.	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Үгүй	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
11.	Монгол Улсын Үндсэн хууль, болон Монгол улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	-	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
12.	Хуулийн төслийн зүйл, заалт жөндөрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	-	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
13.	Хуулийн төсөлд шударга	-	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй

	бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх		асуудал тогтоогдоогүй.
14.	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	үгүй	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
15.	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Тийм	Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 9-т энэ талаар зохицуулсан

## **ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ**

### **5.1. Үнэлэлт, дүгнэлт**

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ шалгуур үзүүлэлт бүрээр дараахь байдлаар үнэлж дүгнэлээ.

#### **Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтээр:**

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийхэд зорилгодоо хүрэх байдлын шалгуур үзүүлэлтэд нийцсэн гэж дүгнэж байна.

#### **Практикт хэрэгжих боломж гэсэн шалгуур үзүүлэлтээр:**

Сонгож авсан зохицуулалтын хувьд дараахь дүгнэлтийг хийлээ. Хуулийн төслийн энэ зохицуулалтын хувилбарыг практикт хэрэгжүүлэхэд захиргааны байгууллагын хувьд өргөдөл, гомдол бүртгэл, хуваарилалттай холбоотой үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах шаардлага үүсч байна. Тухайн зохицуулалтыг

захиргааны байгууллага өөрийн үзэмжээр тайлбарлаж хэрэгжүүлэхээс зайлсхийх зорилгоор шийдвэр гаргалтын хэлбэрийг хуулиас эшлэх эсхүл тодорхой дурдах шаардлагатай гэж үзлээ.

#### **Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр:**

Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг судлахдаа, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг тогтоолоо. Уг дүгнэлтээр хуулийн төсөлд хоёрдмол утгатай үг хэллэг, хүч оруулсан үг хэллэг хэрэглэсэн зарим зохицуулалтын томъёоллыг өөрчлөх шаардлагатай гэж үзсэн болно.

#### **Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр:**

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгасан. Харилцан уялдаатай байдлыг хангасан.

## **4.2. Зөвлөмж**

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг тооцох ажиллагааны үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан дараахь зөвлөмжүүдийг гаргаж байна.

*Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:*

- Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 8-д “92.4-т” гомдол гаргах хэлбэрт тусгай дугаарт ирүүлсэн гомдлыг нэмж тусгах. Үүнтэй холбогдуулан төслийн 10-т мөн холбогдох өөрчлөлт оруулах.
- Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 11-д “...шийдвэрлэхгүй байж болно” гэснийг “шийдвэрлэхгүй” гэж өөрчлөлт оруулах.
- Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 13-т заасан “... учирсан хохирлыг хариуцан арилгах журам”-ыг үүнтэй холбоотой бүхий л харилцааг цогцоор нь зохицуулахаар бичвэрт холбогдох өөрчлөлтийг оруулах.
- Улсын Их Хурлаас гаргаж буй бүхий л шийдвэр Засгийн газарт чиглэл өгөх шинжтэй байдгийг анхаарч Хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 1-ийн бичвэрт холбогдох өөрчлөлтийг оруулах.

*Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:*

- Хуулийн төслийг дагалдан гарах бусад хуулийн төслийг боловсруулах.
- Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3, 9 дэх хэсэгт хэрэглэсэн хүч хэрэглэсэн үгийг хасах.
- Хуулийн төслийн бичвэрийг нэг стандартад оруулах.

Харилцан уялдаа холбоотой шалгуур үзүүлэлтийн хүрээнд тусгайлан өгөх санал байхгүй бай практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хууль хэрэглэгч иргэд, хуулийн этгээдүүдэд хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд ойлгомжтой байх зорилгоор шийдвэр гаргалтын хэлбэрийг хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 12 дахь хэсэгт тодорхой тусгах шаардлагатай гэж үзэж байна.

## **АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ**

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхдээ дараахь эх сурвалжийг ашигласан болно. Үүнд:

1. Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
2. Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлалын төсөл
3. Захиргааны ерөнхий хууль-2017 он
4. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль-1995
5. Хууль тогтоомжийн тухай хууль, аргачлал, гарын авлага, Хууль зүй, дотоод хэргийн яам, 2016 он
6. Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал” Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт
7. Захиргааны ерөнхий хуулийн тайлбар, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, “Эрх зүйн боловсрол” академи-2017 он
8. Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, “Эрх зүйн боловсрол” академи

---ooOoo---